

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 21

№ *Т/43*


Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлыг албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Эм жи эл акуа ХК-ийн дүрмийн 7.21.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хархүү овогтой Тэгшээг Эм жи эл акуа ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас 2025 оны 05 сарын 21 өдрөөр чөлөөлсүгэй.
2. Х.Тэгшээтэй холбогдох тооцоог хийж, ажил хүлээлцэхийг гүйцэтгэх захирлын орлогч Б.Бат-Оргилд даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.БИЛГҮҮН

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 21

№ 7/44

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Эм жи эл акуа ХК-ийн дүрмийн 7.21.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэр-Од овогтой Алтантуяаг Эм жи эл акуа ХК-ийн гүйцэтгэх захирлаар 2025 оны 05 сарын 21 өдрөөс эхлэн томилсугай.
2. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу онцгой нөхцөл бүхий гэрээг С.Алтантуяатай байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Л.Билгүүн/-д үүрэг болгосугай.
3. Компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хууль болон гэрээнд заасан хугацаанд ажлаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг гүйцэтгэх захирал /С.Алтантуяа/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит эрсдлийн хороонд даалгасугай.
5. Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Намхайдорж/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.БИЛГҮҮН